



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хотонт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/116/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn</p> <p>Аудитор Л.Соёлмөнх Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал, дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.5 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг

Утас/Факс: 976-70333141

И-мэйл: arkhangai@audit.gov.mn

Г ХОТОНТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Д.ЭРДЭНЭБУЛГАН ТАНАА

2022.02.24 № 88
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хотонт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Хотонт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021.12.31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,560,724.77	129,564,287.48
33	АВЛАГА	0.00	83,386,300.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0.00	83,386,300.00
35	БАРАА МАТЕРИАЛ	17,560,724.77	46,177,987.48
35100	Түүхий эд материал	8,169,055.04	36,426,317.75
35130	Эм боох материал	8,169,055.04	36,426,317.75
35400	Хангамжийн материал	9,391,669.73	9,751,669.73
35410	Бичиг хэргийн материал	60,000.00	60,000.00
35420	Аж ахуйн материал	9,061,669.73	9,061,669.73
35440	Түлш, шатах тослох материал	270,000.00	630,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	343,629,321.26	409,565,016.83
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	343,629,321.26	409,565,016.83
39200	Биет хөрөнгө	326,551,321.26	392,487,016.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	293,867,900.33	293,867,900.33
39202	Хуримтлагдсан элэгдэл	-46,911,906.96	-53,601,193.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	62,628,925.00	105,207,150.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-38,602,457.56	-48,082,607.47
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	89,381,485.83	147,910,343.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	-67,812,261.00	-79,081,536.67
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	45,688,086.00	45,688,086.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,713,242.38	-26,320,917.02
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,500,000.00	13,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,475,208.00	-6,600,208.00
39300	Биет бус хөрөнгө	17,078,000.00	17,078,000.00
39301	Програм хангамж	385,000.00	385,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-385,000.00	-385,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	17,078,000.00	17,078,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	361,190,046.03	539,129,304.31
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	361,190,046.03	539,129,304.31
51	Засгийн газрын хувь оролцоо	361,190,046.03	539,129,304.31
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	396,988,298.21	396,988,298.21
51200	Хуримтлагдсан үр дүн	-41,693,036.86	136,246,221.42
51210	Өмнөх үеийн үр дүн	-27,538,764.19	-41,693,036.86
51220	Тайлант үеийн үр дүн	-14,154,272.67	177,939,258.28
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,894,784.68	5,894,784.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	361,190,046.03	539,129,304.31

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	528,355,172.71	1,311,849,320.03
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	55,971,592.71	397,143,520.03
120	Нийтлэг татварын бус орлого	55,971,592.71	397,143,520.03
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	13,800,700.00	76,487,082.63
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	42,170,892.71	320,656,437.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	472,383,580.00	914,705,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	419,533,700.00	469,385,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	419,533,700.00	469,385,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,356,400.00	411,051,200.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	47,400.00	13,700.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	2,657,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,309,000.00	324,273,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	720,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	0.00	83,386,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	13,066,700.00	14,221,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,066,700.00	14,221,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	38,426,780.00	20,048,200.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	38,426,780.00	20,048,200.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	542,509,445.38	1,133,910,061.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	542,509,445.38	1,133,910,061.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	542,509,445.38	1,068,910,061.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	317,750,000.00	428,424,900.00
210101	Үндсэн цалин	202,500,000.00	202,500,000.00
210102	Нэмэгдэл	88,136,000.00	153,710,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,864,000.00	0.00
210104	Урамшуулал	20,250,000.00	38,734,700.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	33,480,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,896,300.00	57,460,000.00
210201	Тэтгэврийн даатгал	30,186,300.00	42,511,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,177,500.00	3,737,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,542,000.00	2,989,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	635,500.00	747,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,355,000.00	7,474,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,220,700.00	12,492,174.00
210301	Гэрэл, цахилгаан	3,486,200.00	3,772,938.00
210302	Түлш, халаалт	8,734,500.00	8,719,236.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,563,200.00	64,299,800.00
210401	Бичиг хэрэг	2,300,000.00	3,315,500.00
210402	Тээвэр, шатахуун	17,306,400.00	18,813,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,306,800.00	1,306,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	1,493,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,150,000.00	39,370,700.00

2105	Нормативт зардал	66,434,394.67	455,548,272.69
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	59,384,394.67	402,501,432.69
210502	Хоол, хүнс	5,750,000.00	48,046,840.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,300,000.00	5,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,800,000.00	9,900,500.00
210604	Урсгал засвар	1,800,000.00	9,900,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,200,000.00	700,000.00
210702	Дотоод албан томилолт	1,200,000.00	700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,250,945.00	963,028.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,150,945.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	40,000.00	80,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	47,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	750,000.00	585,528.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,393,905.71	39,121,387.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,735,000.00	3,950,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,658,905.71	35,171,387.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	65,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	65,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	35,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	30,000,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-14,154,272.67	177,939,258.28
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-14,154,272.67	177,939,258.28

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	396,988,298.21	5,894,784.68	-27,538,764.19	375,344,318.70
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	396,988,298.21	5,894,784.68	-27,538,764.19	375,344,318.70
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-14,154,272.67	-14,154,272.67
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	396,988,298.21	5,894,784.68	-41,693,036.86	361,190,046.03
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	396,988,298.21	5,894,784.68	-41,693,036.86	361,190,046.03
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	396,988,298.21	5,894,784.68	-41,693,036.86	361,190,046.03
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	177,939,258.28	177,939,258.28
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	396,988,298.21	5,894,784.68	136,246,221.42	539,129,304.31

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	472,383,580.00	831,319,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	472,383,580.00	831,319,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	419,533,700.00	469,385,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	419,533,700.00	469,385,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,356,400.00	327,664,900.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	47,400.00	13,700.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	2,657,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,309,000.00	324,273,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	720,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	13,066,700.00	14,221,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,066,700.00	14,221,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	38,426,780.00	20,048,200.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	38,426,780.00	20,048,200.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	470,533,580.00	806,699,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	470,533,580.00	806,699,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	470,533,580.00	741,699,500.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	317,750,000.00	428,424,900.00
210101	Үндсэн цалин	202,500,000.00	202,500,000.00
210102	Нэмэгдэл	88,136,000.00	153,710,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,864,000.00	0.00
210104	Урамшуулал	20,250,000.00	38,734,700.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	33,480,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,896,300.00	57,460,000.00
210201	Тэтгэврийн даатгал	30,186,300.00	42,511,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,177,500.00	3,737,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,542,000.00	2,989,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	635,500.00	747,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,355,000.00	7,474,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,490,700.00	13,116,287.00
210301	Гэрэл, цахилгаан	3,486,200.00	4,037,051.00
210302	Түлш, халаалт	9,004,500.00	9,079,236.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,393,200.00	64,299,800.00
210401	Бичиг хэрэг	2,300,000.00	3,330,000.00
210402	Тээвэр, шатахуун	16,136,400.00	18,813,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,306,800.00	1,306,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	1,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,150,000.00	39,349,300.00
2105	Нормативт зардал	28,017,435.00	162,884,985.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,967,435.00	109,838,145.00
210502	Хоол, хүнс	5,750,000.00	48,046,840.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,300,000.00	5,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,800,000.00	9,900,500.00
210604	Урсгал засвар	1,800,000.00	9,900,500.00

2107	Томилолт, зочны зардал	1,200,000.00	700,000.00
210702	Дотоод албан томилолт	1,200,000.00	700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,250,945.00	963,028.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,150,945.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	40,000.00	80,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	47,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	750,000.00	585,528.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,735,000.00	3,950,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,735,000.00	3,950,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	65,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	65,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	35,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	30,000,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,850,000.00	24,620,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,850,000.00	24,620,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,850,000.00	24,620,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,850,000.00	24,620,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,850,000.00	24,620,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,850,000.00	-24,620,000.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	528,744,200.00	503,654,600.00	25,089,600.00	95.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	528,744,200.00	503,654,600.00	25,089,600.00	95.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	528,744,200.00	503,654,600.00	25,089,600.00	95.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	373,714,900.00	373,714,900.00	0.00	100.00
210101	Үндсэн цалин	202,500,000.00	202,500,000.00	0.00	100.00
210102	Нэмэгдэл	99,000,000.00	99,000,000.00	0.00	100.00
210104	Урамшуулал	38,734,700.00	38,734,700.00	0.00	100.00
210105	Гэрээт ажлын хөлс	33,480,200.00	33,480,200.00	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,451,500.00	50,451,500.00	0.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	35,502,900.00	35,502,900.00	0.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,737,200.00	3,737,200.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,989,700.00	2,989,700.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	747,400.00	747,400.00	0.00	100.00

Хотонт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	7,474,300.00	7,474,300.00	0.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,421,000.00	12,421,000.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	2,975,000.00	4,037,051.00	-1,062,051.00	135.70
210302	Түлш, халаалт	9,296,000.00	8,383,949.00	912,051.00	90.19
210303	Цэвэр, бохир ус	150,000.00	0.00	150,000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,456,800.00	30,056,800.00	2,400,000.00	92.61
210401	Бичиг хэрэг	2,300,000.00	2,300,000.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	21,200,000.00	18,800,000.00	2,400,000.00	88.68
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,306,800.00	1,306,800.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,150,000.00	6,150,000.00	0.00	100.00
2105	Нормативт зардал	43,500,000.00	24,977,372.00	18,522,628.00	57.42
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	33,500,000.00	18,747,132.00	14,752,868.00	55.96
210502	Хоол, хүнс	7,500,000.00	6,230,240.00	1,269,760.00	83.07
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,500,000.00	0.00	2,500,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,550,000.00	3,620,000.00	3,930,000.00	47.95
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,750,000.00	1,820,000.00	3,930,000.00	31.65
210604	Урсгал засвар	1,800,000.00	1,800,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	700,000.00	700,000.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	700,000.00	700,000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,200,000.00	963,028.00	236,972.00	80.25
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	80,000.00	80,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	47,500.00	72,500.00	39.58
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	750,000.00	585,528.00	164,472.00	78.07
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,750,000.00	6,750,000.00	0.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,750,000.00	6,750,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	528,744,200.00	503,654,600.00	25,089,600.00	95.25
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	469,385,400.00	469,385,400.00	0.00	100.00

310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	469,385,400.00	469,385,400.00	0.00	100.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	14,221,000.00	14,221,000.00	0.00	100.00
320001	Орон нутгийн төсвөөс	14,221,000.00	14,221,000.00	0.00	100.00
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	45,137,800.00	20,048,200.00	25,089,600.00	44.42
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	45,137,800.00	20,048,200.00	25,089,600.00	44.42
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	25	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	19	19	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	5	5	0.00	100.00

2.5 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	327,664,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	327,664,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	262,664,900.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	54,710,000.00
210102	Нэмэгдэл	54,710,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,008,500.00
210201	Тэтгэврийн даатгал	7,008,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	695,287.00
210302	Түлш, халаалт	695,287.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,243,000.00
210401	Бичиг хэрэг	1,030,000.00
210402	Тээвэр, шатахуун	13,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	33,199,300.00
2105	Нормативт зардал	137,907,613.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	91,091,013.00
210502	Хоол, хүнс	41,816,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,100,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00
210602	Тавилга	10,000,000.00
210603	Урсгал засвар	8,100,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	65,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	35,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	327,664,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	327,664,900.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс авсан хандив, тусламж	13,700.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,657,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	324,273,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	720,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хотонт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Соёлмөнх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хотонт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хотонт сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл зан үйл төлөвшүүлж ээлтэй орчин бүрдүүлсэн сэтгэлд хүртэл үйлчилсэн шилдэг эрүүл мэндийн төв болох алсын харааг тодорхойлсон байна. Тус байгууллага нь хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ээлтэй орчинд жигд хүртээмжтэй, түргэн шуурхай, чанартай үзүүлж эрүүл амьдралын хэв маягийг сурталчилах ажлыг өргөжүүлсэн анхан шатны эмнэлэг болох зорилготой нийгмийн болон эмнэлгийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хүргэх чиг үүрэг бүхий аймгийн ТЕЗ-ийн харьяа тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага байна.

Тус байгууллага нь тайлант онд дараах зорилтуудыг тавин ажилласан байна. Үүнд:

- ✓ Чанар аюулгүй байдлын удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох, тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг тасралтгүй хэмжиж сайжруулах
- ✓ Чанар сайжруулах хэрэгсэл нэвтрүүлж хэрэгжүүлэх түгээн дэлгэрүүлэх
- ✓ Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх
- ✓ Нотолгоонд суурилсан анагаах ухааныг хөгжүүлэх
- ✓ Үйлчлүүлэгч төвтэй тусламж үйлчилгээг хөгжүүлэх
- ✓ Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэн хянах тоог олон улсын жишигт ойртуулах
- ✓ Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах эрсдэлийг бууруулах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-иар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн.
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 67/А/268, А/387/99 дугаар тушаал “Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг ссанхүүжүүлэх журам, тусламж үйчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай”
- Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/496 дугаар тушаал “Нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох тухай”
- Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/605 дугаар тушаал “Журам, аргачлал батлах тухай”
- Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/585 дугаар тушаал “Мөнгөн тэтгэмж олгох тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хотонт сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын багийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд тайлант хугацаанд байгууллагын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нэгдсэн журмыг боловсруулан батлуулж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Дотоод хяналт шалгалт хийх жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан 5 чиглэлийн хүрээнд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- ❖ Хүлээн авах, яаралтай тусламжийн бэлэн байдал, анхан шатны маягт хөтлөх Эрүүл мэндийн сайдын А/611 дүгээр тушаалын хэрэгжилт
- ❖ Халдварын хяналт сэргийлэлт ариутгал, халдваргүйтгэл, угаалга цэвэрлэгээ, хог хаягдлын менежмент
- ❖ Шинэ коронавирусын халдварын эсрдэлээс сэргийлэх бэлэн байдал
- ❖ Өвчний түүх бичих стандарт мөрдөлт
- ❖ Санхүү, төсвийн гүйцэтгэлд хийгдэх дотоод хяналтын талаар хяналт шалгалтыг хийж 30 зөрчлийг илрүүлж, зөрчил арилгах үүрэг даалгаврыг өгч ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурель сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу хөтөлбөр, арга хэмжээгээр бэлтгэж, тайлбар танилцуулгын хамт ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 528.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 5.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 3.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 49.3 хувиар өссөн материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, данс байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	хувь
Авлага	0	83.4	83.4	
Бараа материал	17.56	46.17	28.6	162.9
Үндсэн хөрөнгө	343.62	409.56	65.9	19.2
Нийт хөрөнгө	361.9	539.12	177.9	49.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	361.19	539.12	177.9	49.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	361.19	539.2	177.9	49.3

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлагын дансны үлдэгдэл тайлант онд 83.4 сая төгрөгөөр өссөн нь ЭМДС-аас авах ковидын цогц тусламж үйлчилгээний санхүүжилт нэхэмжилснээс дутуу ирсэнтэй холбоотой байна.
- Бараа материал эхний үлдэгдлээс 162.9 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 17.5 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 245.3 сая төгрөг, хандиваар 320.6 сая төгрөг,

нийт 565.9 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 537.3 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан оны эцэст 46.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 19.2 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 522.5 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд үндсэн үйл ажиллагааны санхүүжилтээр 4.6 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтээс 20.0 сая төгрөгийн компьютер, техник хэрэгслийг худалдан авч, аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 388 тоот албан бичиг, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 734 тоот албан бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу нийт 24.6 сая төгрөгийг орлогод бүртгэсэн байна. Мөн Эрүүл мэндийн яамнаас 12.3 сая төгрөгийн, аймгийн Эрүүл мэндийн газраас 4.1 сая төгрөгийн, аймгийн Засаг даргын Тамгын газраас 19.4 сая төгрөгийн, Хотонт сумын Засаг даргын Тамгын газраас 24.2 сая төгрөгийн, иргэн н.Батсайханаас 2.5 сая төгрөгийн, иргэн н.Догсомын гэр бүлээс 14.0 сая төгрөгийн нийт 76.5 сая төгрөгийн хандив тусламж өгснийг данс бүртгэлд тусгаж, үндсэн хөрөнгө нийт 101.1 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 214.0 сая төгрөгийн элэгдлээр буурч, 409.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн 177.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй шууд холбоотой бөгөөд тайлант хугацаанд 177.9 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	55.97	397.14	341.17
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	419.53	469.38	49.85
Нэмэлт санхүүжилт	1.56	411.05	409.49
Орон нутгийн төсвөөс	13.06	14.22	1.16
Эрүүл мэндийн даатгалын сангаас	38.42	20.04	-18.38
Үйл ажиллагааны орлого	528.54	1,311.83	783.29
Цалин, шимтгэлийн зардал	360.64	485.88	125.24
Бараа ажил үйлчилгээний зардал	105.41	542.94	437.53
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38.25	0.96	-37.29
Бараа үйлчилгээний бусад зардал	38.39	39.12	0.73
Урсгал шилжүүлэг	0.00	65.00	65.00
Хөрөнгийн зардал	0.00	0.00	0.00
Үйл ажиллагааны зардал	542.69	1133.9	591.21
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-14.15	177.93	192.08

Хотонт сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 783.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээний санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон, мөн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн

5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 556.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 28.0 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 528.7 сая төгрөгөөр хянаж баталсан бол тодотголоор батлагдсан төсөвт өөрчлөлт ороогүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 528.7 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 25.0 сая төгрөгийн санхүүжилт Эрүүл мэндийн даатгалын сангаас дутуу авсан байна. Тайлант онд 503.6 сая төгрөгийн санхүүжилтийг авч, бүрэн зарцуулсан бөгөөд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй тайлагнагдсан байна. Энэ нь Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлэх болсонтой холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар ЭМДС-аас ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээний санхүүжилт 289.2 сая төгрөг, Эрүүл мэндийн сайдын А/496, А/585 дугаар тушаалын дагуу коронавируст халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг урамшуулах зорилгоор олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 35.0 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс 2.7 сая төгрөг, Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбооноос сорьц тээвэрлэх зардалд 0.1 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 0.7 сая төгрөг нийт 327.6 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна. Ирсэн санхүүжилтийг зарцуулах эрхийн хүсэлт нээлгэн зарцуулсан бөгөөд цалин шимтгэлд 61.7 сая, байр ашиглалтын зардалд 0.7 сая, хангамж, бараа материалын зардалд 34.2 сая, эмийн зардалд 91.1 сая, хоол хүнсэнд 41.8 сая, нормын хувцас зөөлөн эдлэлд 5.0 сая, багаж техник хэрэгсэлд 20.0 сая, урсгал засварт 8.1 сая, мөнгөн тэтгэмжид 35.0 сая, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 30.0 сая төгрөгийг тус тус зарцуулж тайлант оны эцэст үлдэгдэлгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Хотонт сумын Эрүүл мэндийн төв нь тайлант жилд ковид-19 халдварын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг нийт 429 хүнд үзүүлж ЭМДС-аас 392.7 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилж гүйцэтгэлээр 309.3 сая төгрөг авч оны эцэст 83.4 сая төгрөгийн авлагатай тайлагнагдсан.

Хотонт сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд ковид 19 цар тахалтай холбоотойгоор давхардсан тоогоор 3450 иргэнд ПСР-ийн шинжилгээг, 9780 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэгийг, 7688 иргэнд дархлаажуулалтын вакцинийг, 429 иргэнд хэвтэн эмчлүүлэх үйлчилгээг нийт 21347 иргэнд эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.

Эрүүл мэндийн сайдын А/496, А/585 дугаар тушаалын дагуу коронавируст халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан нийт 25 эрүүл мэндийн ажилтанд нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 35.0 сая төгрөгийг олгосон байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 5 үндсэн зорилтын хүрээнд 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 92.0 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 528.7 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 95.2 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэлэхэд Үүнд:

- Тус байгууллага нь тайлант онд 320.6 сая төгрөгийн бараа материал, 76.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хандив тусламжаар авч тайланд бүрэн тусгасан байна.
- Тайлант жилд коронавируст халдвараар өвчилсөн 51 иргэдэд гэрээр тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Суудлын автомашин ашиглалтын хувьд: Тус байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2 тээврийн хэрэгсэлд 18.8 сая төгрөгийн шатахуун, 2.4 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл зарцуулсан, орон тооны 1 жолоочтой, жолоочийн цалинд 14.7 сая төгрөгийг олгожээ.

Харин бусад судалгаанд хамаарах мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжууллаа. /Local.audit.mn сайтад шивсэн/

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хотонт сумын Эрүүл мэндийн төв нь тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулахаас 151 мэдээллийг хугацаанд бүрэн ил тод мэдээллэж ажилласан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцэж байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд бараа үйлчилгээний бусад зардлаас анхан шатны баримтгүй 1.2 сая төгрөгийн 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан, цалингийн давтан тооцооллоор 0.6 сая төгрөгийн цалин, үр дүнгийн урамшуулал илүү олгосон зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоосон, төсөвт зохицуулалт хийхгүйгээр 3.1 сая төгрөгийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн, дотоод хяналттай холбоотой зөвлөмж өгч биелэлтийг бүрэн хангуулсан.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нэмэлт санхүүжилт, хандив тусламжийн зарцуулалтыг авч үзэх нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2.0 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 1.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоох, анхан шатны баримттай холбоотой 1.0 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүллээ.

4.1 Төлбөрийн акт

Цалингийн давтан тооцооллоор 9 ажилтанд үндэслэлгүйгээр 0.7 сая төгрөгийн урамшууллыг олгосон, эх баригчид 0.3 сая төгрөгийн урамшууллыг илүү олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийг хэмнэлтийн Засгийн газрын 43 дугаар тогтоол болон Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

4.2.1. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд нярвын тайланд 0.9 сая төгрөгийн эм боох материалыг дутуу орлогод авсан мөн шатахууны 0.1 сая төгрөгийн шатахууны үлдэгдлийг бараа материалын журналд үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтыг мөрдөж ажиллах зөвлөмжийг өгч байна.

Зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
		2	2.0	0	0	1	1.0	0	0	1	1.0
	дүн	2	2.0	0	0	1	1.0	0	0	1	1.0
	Нийт дүн	2	2.0	0	0	1	1.0	0	0	1	1.0